*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

**Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар** *(нэгжийн нэр)-н* ***Нийгмийн халамжийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч*** *(албан тушаалын нэр)****Доржсүрэнгийн Гэрэлтуяагийн*** *(албан хаагчийн овог, нэр)*-н

**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ “Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.”** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1**<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах | Шинэчлэн төлөвлөсөн арга хэмжээ, тоо | 0% | 80% | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу халамжийн салбарын өнгөрсөн 4 жилийн хугацаанд хийгдсэн судалгаа, шинжилгээ, тайлан болон мандатын шинжилгээнд тулгуурлан орчны шинжилгээг боловсруулсан. 2025-2028 онд халамжийн чиглэлээр 3 зорилт, 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгалаа.<br>“Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/119 дүгээр тушаалаар батлуулсан. | 01-05 | 92.9 |
| 2. | **Арга хэмжээ 1.2**<br>Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд хариуцсан чиглэлээр санал, тооцоолол боловсруулах | Боловсруулж тусгасан санал, тоо | 0% | 50% | Монгол Улсын 2026 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнд халамжийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, дунд хугацааны чиг хандлага, 2019-2023 оны тоон мэдээллийг гаргаж, ирэх онд халамжийн чиглэлээр хэрэгжүүлэх 2 арга хэмжээний саналыг тайлбар, тооцоолллын хамт халамжийн хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, төсөлд тусгуулсан. | 01-08 | 64.3 |
| 3. | **Арга хэмжээ 1.3**<br>Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт | | 0% | 40% | Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ж.Баясгалан ахлан ажиллаж байна. Япон Улсын асрах үйлчилгээний нөхцөл байдалтай танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах зорилгоор УИХ-ын | 02-11 | 57.1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах, саналын хувилбар, тооцоолол боловсруулах | Ажлын гүйцэтгэл, хувь | | | гишүүн Ж.Баясгалангаар ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 2 дугаар сард тус улсад туршлага судалж ажилласан. Туршлага судлах багт яамны холбогдох газар, хэлтсийн дарга нар оролцож тус улсын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргаа, сувилгаа, нийгмийн хамгааллын хууль, эрх зүйн чиглэлээр харилцан мэдлэг мэдээллээ солилцож ажилласан.<br>Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгээс 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдөр ГБХНХЯ, ЭМЯ болон бусад холбогдох төрийн болон ТББ-ын байгууллагын төлөөллийг оролцуулсан "Асрах үйлчилгээний эрх зүйн орчин" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Яамны халамжийн хэлтсийн дарга Ю.Отгонбилэг, ахлах шинжээч Д.Гэрэлтуяа нар оролцож "Ахмад настны асаргаа, үйлчилгээ өнөөгийн байдал" сэдвээр илтгэл танилцуулсан. Ажлын хэсгээс дараагийн хурлаар асрах үйлчилгээг хэрэгжүүлж байгаа ТББ-уудын танилцуулга, мэдээллийг сонсох, бусад шийдлүүдийг хэлэлцэхээр тогтсон. | | |
| 4. | **Арга хэмжээ 1.4**<br>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгүүдэд ажлын хэсэгт ажиллах, шаардлагатай баримт бичгийг хариуцан боловсруулах | Шинэчлэн боловсруулсан баримт бичгийн тоо | 0% | 50% | Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж сайд, яамны удирдлагад танилцуулж, холбогдох ТББ, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагаар хэлэлцүүлж Засгийн газрын гишүүдээс санал авахад бэлэн болгов.<br>Түүнчлэн хуулийн төслийг дагалдуулан 20 дагалдах хуулийн төсөл, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээг боловсруулах болон хуулийн ажлын хэсгийн хурлыг 1 дүгээр сарын 16-ны өдөр, дэд ажлын хэсгийн хурлыг 22-ны өдөр, төрийн бус байгууллага, аймаг, дүүргийн халамжийн газар, хэлтсийн дарга нарын хэлэлцүүлгийг 29-ний өдөр зохион байгуулахад тус тус хамтран ажиллав.<br>Хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуульд заасан бүрдүүлбэрийг хангаан Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 01/1454 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлэв.<br>УИХ-д өргөн мэдүүлэхтэй холбоотой хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг хуулийн төслийн бүлэг тус бүрээр багцлан тайлбар, танилцуулгыг ажлын хэсэгт боловсруулж өгсөн. | 01-12 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 1.5**<br>ЕТГ-ын "Эхийн алдар" одонгоор шагнах журам боловсруулах | | 0% | 100% | ЕТГ-аас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу "Эхийн алдар" одонгоор шагнах журам боловсруулах ажлын хэсэгт ТНБД | 01-03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын хэсэгт ажиллах, холбогдох хууль, журмын төсөлд санал боловсруулж хүргүүлэх | Боловсруулсан баримт бичгийн тоо | | | Л.Мөнхзул ажиллаж, ажлын хэсгийн гишүүнийг холбогдох мэдээллээр хангах ажиллав.<br>ТНБД-аас өгсөн чиглэлийн дагуу Эхийн алдар" одонгоор шагнах журмын төсөлд холбогдох саналыг, одонтой эхчүүдийн талаарх мэдээллийн хамт боловсруулж өгсөн. Түүнчлэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэж өгсөн. | | |
| 6. | **Арга хэмжээ 1.6.**<br>"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5 жилийн тайланг салбарын эрхлэх асуудлын хүрээнд гаргах, ажлын хэсэгт хүргүүлэх | Ажлын гүйцэтгэл, хувь | 0% | 100% | "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9 зорилго, 73 шалгуур үзүүлэлтээс ГБХНХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах 2 зорилгын 51 үйл ажиллагаа, 1 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, гол ахиц, үр дүн, анхаарах асуудлыг 2020-2025 оноор гарган ЗГХЭГ-ын ажлын хэсэгт хүргүүлсэн бөгөөд яамны холбогдох мэдээ мэдээллээр хангаж ажлын хэсгийг хангаж ажиллав.<br>Түүнчлэн ажлын хэсгээс боловсруулж санал авахаар ирүүлсэн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5 жилийн тайлангийн төсөлтэй танилцаад Хүний хөгжил болон Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын салбарын эрхлэх асуудалд хамаарах хэрэгжилтэд холбогдох саналыг тусган Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 02/1707 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 01-06 | 100 |
| **Зорилт 2. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ "......гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, *олон нийттэй харилцах....... зорилтын хүрээнд:"*** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.**<br>Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайд нарт зориулсан ГБХНХЯ-ны танилцуулга мэдээллийн агуулгыг нэгтгэн боловсруулах | Ажлын гүйцэтгэл, хувь | 0% | 80% | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Элчин сайд нартай уулзах уулзалтад зориулж салбарын хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа цаашдын зорилтын талаар танилцуулга, мэдээллийн агуулгыг боловсруулав. Салбарын сайд Европын холбооны улсаас Монгол Улсад суугаа элчин сайд нартай уулзах уулзалт 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2024-2028 онд хийх бодлогын шинэчлэлийг танилцууллаа.Энэ хүрээнд танилцуулга мэдээллийг хэвлэж сайд нарт гарын авлага мэдээлэл болгож түгээв. | 04-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ 2.2.**<br>Сайд, удирдлагын оролцох хурал, уулзалт, хэлэлцүүлэгт салбарын нэгдсэн бодлого, арга хэмжээний чиглэлээр илтгэл, хэлэх үгийг боловсруулах | Шинэчлэн боловсруулсан мэдээллийн тоо | 0% | 50% | -Яамны ажилтан албан хаагчдад Төрийн нарийн бичгийн даргын танилцуулах "Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам-2025 онд" илтгэлийг бэлтгэв.<br>-Нийгмийн хамгаалын үндэсний тогтолцооны загварыг хэлэлцүүлэх уулзалт, хэлэлцүүлэгт сайдын илтгэл, хэлэх үг болон УИХ-ын даргын хэлэх үгийг боловсруулав.<br>-УИХ-ын гишүүдэд зориулж Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын зорилтуудын биелэлтээр Ярианы сэдэв, түгээмэл асуулт, хариултыг нэгтгэн гаргаж дарга, удирдлагыг мэдээллээр хангав. | 01-12 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 2.3.**<br>УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгөх бусад байгууллага, иргэдээс хариуцсан асуудлын чиглэлээр ирүүлсэн санал, хүсэлт өргөдөл, гомдлыг хүлээн авч судлан үзэж, шийдвэрлэх | Тухайн хугацаанд шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | 0% | 50% | -УИХ-ын гишүүд болон яамдаас санаачлан боловсруулсан хариуцсан асуудлын чиг үүрэгт хамаарах асуудал түүнчлэн яамны газар, хэлтсээс санал авахаар ирүүлсэн журам, дүрмийн төсөлд санал боловсруулж өгсөн. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагийн санаачлан боловсруулсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулж хуулийн хэлтэст өгсөн.<br>-Иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн 14 өргөдөл, санал, хүсэлт ирснээс 8 өргөдөл, хүсэлтэд хариу албан бичиг төлөвлөж хүргүүлж 100 хувь шийдвэрлэв.<br>-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, газрын сарын тайлан, хагас жилийн тайлан болон бусад бодлогын баримт бичгүүдэд холбогдох тайлан, мэдээллийг хугацаанд нь гаргаж ажиллав. | 01-06 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.**<br>Үнэлгээний хорооны хуралд ахлагч болон гишүүнээр ажиллав. | 100% | 0% | 100% | АХБ-ны Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төслийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага, төгсөлтийн аргачлалыг нутагшуулах санал зөвлөмж боловсруулах, ядуурлыг бууруулах стратеги боловсруулах чиглэлээр 3 зөвлөх үйлчилгээ үзүүлэх | 01-03 | 92.9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурлуудыг зохион байгуулж ажиллав. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Нийгмийн халамжийн чиглэлээр бусад оронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дотоодын болон олон улсын байгууллагын судалгааны материалуудыг уншиж судлах | 100% | 0% | 100% | Дэлхийн банкны “Нийгмийн хамгааллын тогтолцооны зохицох чадавх, малчдын уур амьсгалын цочролыг сөрөн тэсвэрлэх чадварыг дээшлүүлэх нь” судалгааг уншиж судалсан.<br>Нийгмийн халамжийн хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Франц, Белги, Австри зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй орнууд хүүхдийн тоо, эцэг эхийн орлогоос хамаарч тэтгэмж, тусламж олгох, олон хүүхэдтэй гэр бүлд татварын хөнгөлөлт үзүүлэх, орон сууцтай болох, өрхийн аж ахуйтай болоход нь хөнгөлөлттэй зээл өгөх арга хэмжээг судалсан.<br>Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа зөвлөхийн боловсруулсан Орос, Польш, Унгар, Франц, Армен зэрэг 14 улсын туршлагыг уншиж судлан хуулийн төслийг боловсруулахад ашиглав. | 01-12 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 2.** Хариуцсан асуудлын чиглэлээр зохих сургалтанд хамрагдах | 100% | 0% | 100% | Яамнаас зохион байгуулж байгаа хувь хүний хөгжлийн сургалтуудад тухай бүр хамрагдаж байна. | 01-12 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| ***Нийгмийн халамжийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч*** | ............................ / Д.Гэрэлтуяа / | 2025 . 06 . 06 . |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

***Нийгмийн халамжийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч*** *(албан тушаалын нэр)* ***Доржсүрэнгийн Гэрэлтуяа***
**ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,**

**МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ "Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ."** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах | 60 | 5 | 65 | 65.0 |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд хариуцсан чиглэлээр санал, тооцоолол боловсруулах | 40 | 5 | 45 | 45.0 |
| 3. | **Арга хэмжээ 1.3** Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах, саналын хувилбар, тооцоолол боловсруулах | 40 | 10 | 45 | 50.0 |
| 4. | **Арга хэмжээ 1.4** Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгүүдэд ажлын хэсэгт ажиллах, шаардлагатай баримт бичгийг хариуцан боловсруулах | 60 | 10 | 70 | 70.0 |

50,0

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | **Арга хэмжээ 1.5**<br>ЕТГ-ын “Эхийн алдар” одонгоор шагнах журам боловсруулах ажлын хэсэгт ажиллах, холбогдох хууль, журмын төсөлд санал боловсруулж хүргүүлэх | 60 | 10 | 70 | 70.0 |
| 6. | **Арга хэмжээ 1.6.**<br>"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5 жилийн тайланг салбарын эрхлэх асуудлын хүрээнд гаргах, ажлын хэсэгт хүргүүлэх | 60 | 10 | 70 | 70.0 |
| **Зорилт 2. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ “......гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх*, олон нийттэй харилцах....... зорилтын хүрээнд:*”** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.**<br>Монгол Улсад суугаа Элчин сайд нарт зориулсан ГБХНХЯ-ны танилцуулга мэдээллийн агуулгыг нэгтгэн боловсруулах | 60 | 10 | 70 | 70.0 |
| 2. | **Арга хэмжээ 2.2.**<br>Сайд, удирдлагын оролцох хурал, уулзалт, хэлэлцүүлэгт салбарын нэгдсэн бодлого, арга хэмжээний чиглэлээр илтгэл, хэлэх үгийг боловсруулах | 60 | 10 | 70 | 70.0 |
| 3. | **Арга хэмжээ 2.3.**<br>УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгөх бусад байгууллага, иргэдээс хариуцсан асуудлын чиглэлээр ирүүлсэн санал, хүсэлт өргөдөл, гомдлыг хүлээн авч судлан үзэж, шийдвэрлэх | 60 | 10 | 70 | 70.0 |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.**<br>Үнэлгээний хорооны хуралд ахлагч болон гишүүнээр ажиллав. | 60 | 5 | 65 | 65.0 |
| **Дундаж оноо:** | | | | 64.5 | 64.5 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | **Арга хэмжээ 1.**<br>**Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.**<br>Нийгмийн халамжийн чиглэлээр бусад оронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дотоодын болон олон улсын байгууллагын судалгааны материалуудыг уншиж судлах | 10,0 | 15 | 15.0 |
| 2. | **Арга хэмжээ 2.**<br>Хариуцсан асуудлын чиглэлээр зохих сургалтанд хамрагдах | 10,0 | 15 | 15.0 |
| **Дундаж оноо** | | | | 15.0 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7.0 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7.0 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 7.0 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7.0 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7.0 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 7.0 | 7.0 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 8.0 |
| 2. | Багаар ажиллах | 8 8.0 |
| 3. | Харилцаа | 8 8.0 |
| **Дундаж оноо** | | 8 8.0 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 64.5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15.0 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 7.0 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8.0 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* 94.5 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 94.5 |

***Үнэлгээ өгсөн:      Нэгжийн дарга***

*Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн*
*газрын дарга* .............................. */Б.Алимаа/*
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.13 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, Төрийн жинхэнэ албан хаагч:***
***зөвшөөрсөн:***

Д.Очмандуул
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.13 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***

В.Жувшинтарал
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

Б.Санчир
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:   Төсвийн шууд захирагч***

.............................. /Л.Мөнхзул/ Л.Мөнхзул
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.20 *(огноо)*

АТА12944 9132155 9024070603